



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 4/35

Булган сум

Аймгийн аварга шалгаруулах Пауэрлифтингийн тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн хэмжээнд Пауэрлифтингийн спортыг сурталчлан таниулах, улсын чанартай тэмцээнд оролцох тамирчдыг бэлтгэх зорилгоор аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 01 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

